



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
САЙХАН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 04 өдөр

Дугаар

A/04

Онги

Үндэсний дээл хувцсаа өмсөж хэвших  
уриалга гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1 дэх хэсэг, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Соёлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх хэсэг, аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/02 захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол үндэсний бахархал болсон өв соёлоо түгээн дэлгэрүүлж, Монгол соёлын дархлааг бий болгох зорилгоор үндэсний дээл, хувцсаа сар бүрийн 3 дахь долоо хоногийн лхагва гаригт өмсөж хэвшүүлэн, залуу хойч үедээ өвлүүлэн уламжлуулахыг сумын нийт албан байгууллага, аж ахуйн нэгжүүдэд уриалсугай.

2. Үндэсний дээл хувцсаа хамт олноороо өмсөж хэвшүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг байгууллагын дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

3. Дээрх уриалгыг албан байгууллага, аж ахуйн нэгжүүдэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулж ажиллахыг Нийгмийн бодлогын мэргэжилтэн, Соёлын төвийн дарга нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЛУВСАНРАГВА

D disk /2024on/A Zahiramj.doc

482/01004

